



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 07/345

Улаанбаатар хот

Г Эрх шилжүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025-2026 онд он дамжин хэрэгжүүлэх “Соёлын төв өргөө”-ний хөрсний ус зайлцуулах, барилгын их засвар, тоног төхөөрөмжийн ажлыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг “Нийслэлийн соёлын төв өргөө” ОНӨААТҮГ (Л.Ариунтуяа)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 3,634,500,000.0 (гурван тэрбум зургаан зуун гучин дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “56”-д заасан “Соёлын төв өргөө”-ний хөрсний ус зайлцуулах, барилгын их засвар, тоног төхөөрөмжийн ажил”-ын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартувшинд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725022207

ପ୍ରକାଶନ ମେଳିମାଲା ୧୦

ପ୍ରାଚୀନୀର କରି କରି କରି ମହାତ୍ମାରେ ଦେଖିଲୁଗରାହାନ୍ତି ଥିଲା.

መ/ቤት በዚህ የዕለታዊ ስራውን እና የሚከተሉት ደንብ መሆኑን የሚያሳይ ይችላል፡፡

ଶ୍ରୀ କାନ୍ତାଜୀର ପତ୍ର

20 20 20 20

ବୁଦ୍ଧି

ବିଜ୍ଞାନ ପରିଚୟ



ପାଇଁବାରୁ
କୁଳାଳିଲେ ଏବଂ କାହାର ମହାଶ୍ୱର ଏବଂ



Digitized by srujanika@gmail.com

ମହାରାଜାଙ୍କର ପଦରେ ଏବଂ ପାତାରାଜାଙ୍କର ପଦରେ ଏବଂ
କାନ୍ଦିଲାଙ୍କର ପଦରେ ଏବଂ କାନ୍ଦିଲାଙ୍କର ପଦରେ ଏବଂ

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
 03 дугаар сарын 09-ны өдрийн
 1945 дугаар захирамжийн
 хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
 “СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨ”-НИЙ ХӨРСНИЙ УС ЗАЙЛУУЛАХ, БАРИЛГЫН
 ИХ ЗАСВАР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЖИЛ**

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	“Соёлын төв өргөө”-ний хөрсний ус зайлуулах, барилгын их засварын ажил (Улаанбаатар хот)	2025	2026	5,100.0	2,126.5
2	“Соёлын төв өргөө”-ний тоног төхөөрөмж, (Улаанбаатар хот)	2025	2025	2,134.5	1,508.0
Нийт дүн				7,234.5	3,634.5